

2010 оноос эхлэн холбооны статусын хувьд гишүүнчлэлтэй байгууллага болсноор эрх барих дээд байгууллага нь Холбооны Их хурал болж оорчлогдсон билээ.

Их хурлын чолоот цагт Холбооны удирдах дээд байгууллага нь Удирдах зовлол байдаг бөгөөд Их хурлыг дорвон жилд нэг удаа Удирдах зовлол зарлан хуралдуулж хуралдааны дэгийг Их хурал тогтооно.

Холбооны гишүүдийн 51-ээс доошгүй хувь ирсэн тохиолдолд хурал хвчинтэйд тооцогдох ба асуудлыг ил санал хураах журмаар ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Холбооны гишүүдийн тавны нэгээс доошгүй хувийн санал, эсвэл Хяналтын зовлолийн шаардлагын үндсэн дээр Удирдах Зовлолийн шийдвэрийн дагуу ээлжит бус Их хурлыг хуралдуулж болно.

Их хурал асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж, хэлэлцсэн асуудлаараа тогтоол гаргах ба түүнд оороор заагаагүй бол уг тогтоол гармагц хвчин тоголдор болно.

Их хурал хуралдуулах хугацаа, хэлэлцэх асуудлын тоолоогоог Удирдах Зовлол баталж, хурал эхлэхээс 30 хоногийн өмнө Холбооны гишүүдэд албан ёсоор мэдэгдэнэ. Мөн Их хурлын талаарх албан мэдээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан гишүүдэд хүргэнэ.

Холбооны гишүүд Их хуралд оороо буюу эрх бүхий албан тушаалтнаар дамжуулж оролцоно. Хэрэв тэдгээр нь хүндэтгэх шалтгаантай бол итгэмжлэгдсэн тоолоогч оролцуулж болно.

Холбооны үйл ажиллагааг зогсоож, татан буулгах асуудлыг нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар шийдвэрлэнэ.

Холбооны гишүүн, удирдах зовлолийн гишүүн, ажилтны хууль бус үйл ажиллагааны улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирол, түүнээс үүсэх хариуцлагыг холбоо хvlлээхгvй.

Холбооны Их хурлын эрх хэмжээ

- Их хурлаар Удирдах зовлол, Хяналтын зовлолийн гишүүдийн тоог тогтоох, сонгох, чолоолох,
- Холбооны үйл ажиллагааны үндсэн чиглэл, дүрмийг хэлэлцэн батлах, оорчлолт оруулах,
- Холбооны үйл ажиллагааны тосов, тайлан тэнцлийг батлах,
- Холбооны үйл ажиллагааны тайлан, илтгэл, хяналтын зовлолийн тайлан, илтгэлийг хэлэлцэж шийдвэрлэх;
- Холбооны дэргэд орон тооны бус салбар, зовлол, комисс зэрэг байгууллагыг байгуулах, татан буулгах, түүний тосвийг батлах,
- Үйл ажиллагааны үндсэн зорилгод нийцсэн тодорхой тослийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэнд хяналт тавих,
- Холбооны гадаад харилцаа, хамтын ажиллагааны үр дүнг хэлэлцэх,
- Холбооны жилийн тосов батлах,
- Холбооны ажлын албаны бүтэц, зохион байгуулалт,
- Торийн бус байгууллагын тухай хууль тогтоомж, энэ дүрэмд заасан бусад асуудлыг эрхлэн гүйцэтгэдэг.

МОНГОЛЫН БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХОЛБООНЫ ГИШҮҮДИЙН АНХДУГААР ИХ ХУРАЛ

Монголын Бэлчээрийн Менежментийн Холбооны гишүүдийн анхдугаар их хурал 2010 оны 1 дүгээр сарын 11-ний одор МБМХ-ны хурлын танхимд болов. **Хэлэлцсэн нь:**

1. Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоог гишүүнчлэлтэй болгох, оорчлон байгуулах шаардлага

Илтгэгч: МБМХ-ны Гүйцэтгэх захирал Д.Дорлигсүрэн

2. МБМХ-ны дүрмийг хэлэлцэж батлах

□ **Илтгэгч:** МБМХ-ны ажилтан Ц.Сүхтулга

3. МБМХ-ны 2010-2013 онд хийх ажлын үндсэн чиглэл

Илтгэгч: МБМХ-ны Гүйцэтгэх захирал Д.Дорлигсүрэн

4. МБМХ-ны гишүүнчлэлийн журам

Илтгэгч: МБМХ-ны ажилтан Ц.Сүхтулга

5. Санал, зовломж

6. Зохион байгуулалтын асуудал: Үүнд: МБМХ-ны Удирдах зовлол болон хяналтын зовлолийг сонгох, МБМХ-ны Гүйцэтгэх захирлыг томилох.

Хуралд МБМХ-ны ажилтнууд, Завхан, Ховд, Увс, Баян-Олгий, Архангай, Говь-Алтай, Баянхонгор, Дундговь, Тов аймгийн сумдыг толоолон 56 толоологч, урилгаар ШХА-ийн Суурин толоологчийн орлогч Матиас Мэйер, ШХА-ийн Үндэсний хотолборийн зохицуулагч Ц.Энх-Амгалан, Ногоон алт тослийн зовлох доктор Д.Аваадорж, доктор С.Жигжидсүрэн, доктор Ё.Загдсүрэн, МААЭШХ-ийн Тэжээл үнэлгээний лабораторийн эрхлэгч, доктор Д.Болормаа нар оролцлоо.

Гишүүд зохион байгуулалтын асуудлаа хэлэлцсэнээр Удирдах зовлолийн гишүүдийг 19, Хяналтын зовлолийг 3 хvний бүрэлдэхvвтэй байхаар тогтлоо. Сонгогдсон Удирдах зовлолийн гишүүд хуралдаж УЗ-ийн тэргvүнээр М.Олонбаярыг, Гvйцэтгэх захирлаар “Ногоон алт” тослийн зохицуулагч, Д.Дорлигсүрэнг сонгов.

УЗ-ийн гишүүд (УЗ): □

1. Н.Тогтохбаяр ХААИС

2.	Л.Даваа	ТУҮҮХолбоо
3.	Д.Аваадорж	МБМХ-ны зовлох
4.	Ё.Загдсүрэн	МБМХ-ны зовлох
5.	С.Жигжидсүрэн	МБМХ-ны зовлох
6.	Д.Болормаа	МБАЭШХ
7.	Д.Банзрагч	БОАЖЯ
8.	Ж.Даваабаатар	ГХБГЗЗГ
9.	М.Олонбаяр	МБМХ-ны ажилтан
10.	М.Сувд	МБМХ-ны хуулийн зовлох,
11.	А.Ахай	Баян-Олгий
12.	А.Отгонбаяр	Ховд
13.	С.Нямдорж	Увс
14.	Ч.Алтанцэцэг	Завхан
15.	Д.Жаргалсайхан	Дундговь
16.	Ц.Оюун	Тов
17.	Б.Эрдэнэбилэг	Баянхонгор
18.	Б.Болдбаатар	Говь-алтай
19.	Ж.Дашзэвэг	Архангай

Хяналтын зөвлөл (ХЗ):

1.	Р.Оросоо	ХААИС-ийн багш, ХЗ-ийн дарга
2.	Оюуннаран	Архангай, Хашаат, БО-ны байцаагч
3.	Н.Ганхуяг	МБМХ-ны ажилтан

Гишүүдээс гаргасан санал, зөвлөмж:

Ё.Загдсүрэн:

1. Дүрэмд МБМХ нь Эрдмийн зовлолтэй байна гэж тусгаагвй байна.
2. Дүрмийн “гишүүнчлэлтэй” гэдгийг “гишүүнд вйлчилдэг” гэж оруулах.
3. Ажлын толовлогооний 1.2-т тусгасан эрдэм шинжилгээний сэтгүүл нь зовхон бэлчээрийн судалгаа гэж явцууралгвй бусад уялдаатай салбарыг хамарсан судалгаа-эрдэм шинжилгээний оргон цар хүрээтэй сэтгүүл баймаар байна.

Д.Дорлигсүрэн:

1. Эрдэм шинжилгээ, хогжлийн хороо болон Эрдмийн зовлолтэй байна гэж дүрэмд тусгах.

Д.Болормаа:

1. Ажлын толовлогоонд хариуцан гүйцэтгэх ажилтны нэрийг тодорхой тавих.
2. Малчид, бэлчээр, малын тэжээл, маркетингийн асуудлыг шийдэх зайлшгүй шаардлагатай. Маркетингийн асуудлыг шийдэхийн тулд мал эмнэлгийн асуудлыг цогцоор нь авч үзэх. Ингэхийн тулд холбоо нь судалгааны ажлаа нарийвчлан хийгээд эндээс гарсан үр дүнг харгалзан цаашид боловсруулах бодлогодоо тусгах.

С.Жигжидсүрэн:

Жалгын нэг тарсан малчдын эрх ашгийг хамгаалсан, тэдний вйл ажиллагааг нэг зорилгын дор нэгтгэн зохион байгуулалтад оруулахад тусалж байгаа ийм холбоо байгуулж байгаа нь их чухал юм. Цагаа олсон зов санаачилга гэж бодож байна.

1. Гишүүн нь элссэн жилдээ гишүүний татвар толох эсэхийг тодруулах. Миний санал бол элссэн жилдээ татвар толохгүй гэж оруулмаар байна.

2. Бэлчээр ашиглагчдын үндэсний чуулганыг бэлчээрийн хууль хэлэлцэхийн омно хийх нь маш том хошвүрэг болно. Үүнээс гадна эрдэм шинжилгээ, вйлдвэрлэлийн бага хурлыг улс, орон нутгийн хэмжээнд хийх, малчдад зориулсан сургалтыг зохион байгуулах /ийм санал малчдаас их ирдэг/, гадаадын бэлчээрийн менежментийн холбоодтой хамтран ажиллах хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг санал байна.

3. Холбоо байнгын идэвхитэй вйл ажиллагааг оорийн орон тодийгвй гадаадад явуулах ёстой. Энэ шаардлагын үүднээс хэлний болон бусад мэдлэг боловсрол сайтай хвнийг Холбооны тэргүүнээр сонгох шаардлагатай. Энэ шаардлагыг МБМХ-нд олон жил ажиллаж байгаа, малын генетикийн мэргэжилтэй, орос англи хэлний мэдлэгтэй М.Олонбаяр эрдэмтэн хангаж байгаа тул түүний нэрийг дэвшүүлж байна.

Гансүх /Ховд, Булган сүм/:

1. Оноо веийн малчдыг 70-аад онд мал дээр гарсан, 90-ээд онд сургууль завсардсан хвмүүс бүрдүүлж байгаа. Тиймээс малчдын залуу халааг бэлтгэх асуудалд

анхаарах.

Ахай /Баян-Өлгий, Цэнгэл сүм/:

1. Цаашдын залгамж халааг бэлтгэх зорилгоор бэлчээрийн мэргэжилтэнг бодлоготойгоор бэлтгэмээр байна.
2. Бодлогын асуудал дээр бэлчээрийн хуулийг батлуулахад хувь нэмрээ оруулах.
3. Малчдын дуу хоолойг яаж тор засагтаа хвргэх талаар бодолцох. Бэлчээр ашиглагчдын үндэсний чуулганыг “Мянган малчны чуулган” шиг шоу болголгвй сайн зохион байгуулах.

Хүрэлчулуун /Ховд, Мөнххайрхан сүм/:

1. Монголын радиод ядаж 7 хоногт 1 удаа явдаг тогтмол нэвтрүүлэгтэй болох.
2. 9 аймгийн 55 сумын ТББ-ын тэргүүнүүд 2010 ондоо ядаж нэг нэг ажил шинээр санаачлаад, түүнийгээ ажил хэрэг болгох. Миний хувьд оорийн сумандаа мал аж ахуйн бүтээгдэхүүний тов байгуулж, 15 хvнийг ажлын байртай болгох зорилт тавьж байна. Ингээд дараа жил уулзахдаа бvгдээрээ 55 брэнд бүтээгдэхүүнтэй уулзаж болно.

Д.Аваадорж:

1. МБМХ нь торийн байгууллагатай хамтарч ажиллана гэсэн заалт оруулах. Тороос зохион байгуулж байгаа ажилд идэвхтэй оролцох. Энэ ажилд гишvн байгууллага идэвхтэй оролцох гэсэн заалтыг оруулах.
2. Холбооноос явуулж байгаа сургалт, судалгааны ажилд гишvндийг хонгололттэй оролцуулах.

Гантөмөр /Ховд, Чандмань сүм/:

1. Мал эрvлжvвлэх асуудлыг үндсэн чиглэлд тодорхой тусгах.
2. Малчдаас гарч байгаа санал, санаачилгыг радио телевизээр сурталчлах.
3. Холбооны бүтцэд анхаарах, дvрэмдээ аймаг, сумдад салбар холбоотой байна гэж оруулах. Эдгээр салбар холбоод нь дvрэм, журмаа оорсдоо боловсруулаад оорсдийн холбооны татвар, хураамжийн асуудлыг оорсдоо дотоод журамдаа тусган зохицуулна

гэж оруулах.

Эрдэнэмягмар /Завхан, Яруу сүм/:

1. Сургууль завсардаад малчин болсон хvмvвсийн сургалтанд анхаарч vндсэн чиглэлд заалт оруулах.

Жаргалсайхан /Дундговь, Өлзийт/:

1. ХААИС-д мэргэжилтэй малчин бэлтгэдэг анги байдагтай адил бэлчээрийн менежментийн чиглэлээр сурч байгаа оюутан, малчдын хvвхдийг сургах асуудалд МБМХ нь оороо болон бусад байгууллагаар дамжуулан дэмжлэг vзвvлнэ гэж vндсэн чиглэлд тусгах.

Отгонбаяр /Ховд, Yенч сүм/:

1. Сурталчилгааг сонин, радиогоор хийснээс телевизээр хийсэн нь vр дvнтэй гэж дvгнэж байна.

2. Малчдад заавал их хэмжээний монго огвол дэмжлэг болдог юм биш. Одоо хvндрэлтэй, хэцvв байгаа вeд нь сэтгэл санааны дэмжлэг болохуйц урмын vг, МБМХ-ноос явуулсан сайхан vг бvхий илгээмж нь бас тус дэм болж малчдын сэтгэл санааг оргосон вйлдэл болно гэж бодож байна.

Одхvв /Ховд, Зэрэг сүм/:

1. МБМХ-ноос гаргаж байгаа “Бэлчээр ногоон алт” сонинд аймаг тус бvр нэг нvвр бэлтгэн гаргаж байвал зvгээр байна.

2. Монголын радиогийн 7 хоногт 2 удаа явдаг “Малчин” нэвтрvлгийн нэг удаагийн дугаарын агуулгыг оорчлон бэлчээрийн асуудлыг тусгах ажлыг зохион байгуулах.

3. Бидний дунд сайхан сайхан ажил хийж байгаа хvмvвс их байна. Эдгээрийн ажлыг сурталчлах тал дээр анхаарч ажиллах.

Дээрх саналуудыг холбооны үйл ажиллагаанд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.
Холбооны дараагийн их хурлыг 2014 онд хийнэ.